

БАЙГУУЛЛАГААС САНХҮҮЖҮҮЛСЭН СУРГАЛТ

1. 2025.05.16-ны өдөр Орон нутаг, дүүргийн арьсны эмч нарын сургалт, уулзалтыг АӨСҮТ-ээс зохион байгууллаа. Уг сургалт, уулзалтын зорилго нь: Арьсны өвчний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг орон нутагт сайжруулахад хувь нэмэр оруулах, орон нутаг, дүүргийн арьсны эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд орон нутаг, дүүргийн арьсны төрөлжсөн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилсан.
2. 2025 оны 06 сарын 25-ны өдөр “Стресс, бухимдлаас ангижрах иога, бясалгалын ач тус” сэдэвт сургалтыг амьдрах урлаг бясалгалын төвийн багш П.Баясгаланбаатар удирдан явуулсан.
3. 2025.06.04-ны өдөр төвийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт сургалт зохион байгуулсан. Ёс зүйн дэд хорооны дарга Б.Баярмаа сургалтыг удирдан явуулсан.
4. 2025.1 сарын 23, 24-ны өдөр төвийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, АУ-ны магистр, арьс судлалын ахлах зэргийн эмч Б.Батцэцэг, АӨСҮТ-ийн зөвлөх эмч, арьс судлалын зөвлөх зэргийн эмч МУ-ын Хүний гавъяат эмч, АУ-ны доктор, профессор Б.Хандсүрэн нар Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн эмнэлгийн ажилчдад мэргэжил арга зүйгээр хангаж, 1 багц цагийн төлбөртэй сургалт зохион байгуулсан.

ГАДААД УЛСАД МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР БОГИНО, ДУНД ХУГАЦААНЫ СУРГАЛТАНД ХАМРАГДСАД:

1. 2025.05.01-2025.05.31 хүртэл БНСУ-ын “SA dermatology” эмнэлэгт НХ-ийн 1 р тасгийн их эмч Э.Баасанхүү, Амбулаторийн тасгийн их эмч Г.Түвшинзаяа нар 1 сарын хугацаанд мэргэжил дээшлүүлсэн.
2. 2025.09.22-2025.10.04 хүртэл TAIWAN INTERNATIONAL HEALTHCARE TRAINING CENTER -t “emergency care and burj injuries management” сэдвээр амбулаторийн их эмч Ч.Эрдэнэчимэг, О.Урангоо нар 14 хоногын хугацаанд мэргэжил дээшлүүлсэн.